

**МОНГОЛЧУУД ТАТВАР ХУРААХ ТҮРЭЭСИЙН
ТОГТОЛЦООГ ХЭРЭГЛЭСЭН НЬ**

Э.ЭНЭРЭЛТ

Товч агуулга: Эл өгүүлэлд Монголын эзэнт гүрэнд татварын түрээсийг хэрхэн ашиглаж байсан талаар авч үзэх болно. Монголчууд олон төрлийн татвар дээр түрээсийн хэлбэрийг ашигладаг байжээ. Татвар хураах ажлыг түрээсээр эрхлэгчид нь ихэвчлэн өндөр орлого хурааж өгөхөөр хаанд амладаг байсан байна. Татвар хураах түрээсийн хэлбэрийг 1230-аад оны сүүлээр монголчууд авч ашигласан бөгөөд уг тогтолцоо Ил хаант улсад цаашид оршсоор байсан нь анхдагч эх сурвалжаар батлагддаг юм. Богино хугацаат түрээсийн гэрээ болон монголчуудын засаг захиргааны хүн хүчний дутагдалтай байдал нь татварын түрээс эрхлэгчид тариачдад зүй бус авирлахад нөлөөлсөн байна. Иймээс татварын түрээсийн хор уршгаас болж монголчууд болон эзлэгдсэн ард түмний хоорондын харилцааг эвдэхэд хүргэсэн байдаг.

Түлхүүр үг: Татварын түрээс, монголчууд, татварын төлбөр, төлөөллийн онол

Удиртгал

Өгэдэйн төр барьсан үед татварын түрээсийн тогтолцоонд төрийн өмнөөс хувь хүмүүсийг ашиглаж эхэлсэн гэж үздэг¹. Энэ үед Их Монгол улсын татварын тогтолцоог боловсронгуй болгох үйл ажиллагаа явагдсан хийгээд төрийн болон алтан ургийн гишүүдийн хэрэгцээ шаардлагын улмаас үе үе, гэнэт хураадаг байсан алба гувчуурын дээр урьдчилан тогтоосон хэмжээгээр, тодорхой хугацаанд хураадаг олон төрлийн татвар, хураамж нэвтэрсэн байна. Үүнийг татварын хувьд гарсан гол өөрчлөлт хэмээн ойлгож болно.

Татварын түрээс гэдэг нь дундад зууны үеийн эдийн засагт цоо шинэ ухагдахуун байгаагүй юм. Татвар хураах түрээсийн тогтолцоог нэн эртнээс төрт улсууд ашиглаж эхэлсэн байдаг. Тухайлбал, Птолемейн эзэнт гүрэн, эртний Ромд төрийн нэрийн өмнөөс хувь хүмүүс татвар хураадаг дадал хэвшил тогтсон

¹ Schurmann, Herbert F. *Economic Structure of the Yuan Dynasty: Translation of Chapters 93 and 94 of the Yuan shih*. Cambridge, Harvard University Press, 1956, 90.

байсан². Исламын их байлдан дагуулалтын дараа Египет зэрэг улсад татвар хураах түрээсийн эрхийг нээлттэй дуудлага худалдаагаар хамгийн өндөр дүн хэлсэн хувь хүмүүст олгодог байжээ³.

Татвар хураах ажлыг түрээсээр хийх нь татвар хураах эрх, хариуцлагыг төрөөс хувь хүнд эсвэл бүлэг этгээдэд шилжүүлэхийг хэлэх бөгөөд татварын түрээсийг захиргааны зардлыг хэмнэх, зээлийн барьцаа бүрдүүлэх, орлогыг өсгөх гэсэн гурван гол шалтгаанаар хэрэглэж байжээ⁴. Татварын түрээсийг харьцангуй үр ашигтай механизм гэж зарим судлаачид үздэг⁵. Тэдний гол дүгнэлт нь татвар хураалтыг хувь хүнд шилжүүлснээр захиргааны зардал буурч, үр ашиг нэмэгдэх явдал юм. Хүн төрөлхтний өнгөрсөн түүхийг авч үзвэл энэхүү өөдрөг дүгнэлт нь ихээхэн эргэлзээг дагуулдаг. Төрөөс тавих хяналт сул эсвэл огт байхгүй байгаа тохиолдолд татварын түрээс нь нийгэм, эдийн засагт ихээхэн хор уршиг авчирдаг байна⁶.

Татварыг хураах түрээсийн хэлбэр монголчуудын эдийн засагт хор хөнөөл учруулж байсан болохыг харуулах нотолгоо бий. Монголчуудтай хамтран ажиллаж байсан татварын түрээс эрхлэгчдийн талаар маш цөөн тооны хятад, перс сурвалжуудад өгүүлсэн байдаг бөгөөд уг асуудалд ихээхэн шүүмжлэлтэй өнгө аясаар хандсан байдаг. Тэдгээр сурвалжуудын бараг бүгдийг нь монголчуудын албанд ажиллаж байсан хүмүүс бичжээ. Тухайлбал, Елюй Чуцайн булшны бичигт татварын түрээсийн ажил эрхлэгчид төрийн нөлөө бүхий түшмэдүүдийн дэмжлэгийг шударга бусаар олж авч, эзлэгдсэн ард олонд татварын дарамт учруулж байсан талаар өгүүлдэг⁷. Мөн татварын түрээс эрхлэгчдийн хууран

² Птолемейчуудын төрийн санхүү, засаг захиргааны талаар бичигдсэн сайн бүтээл бол Brian Paul Muhs. *The Administration of Egyptian Thebes in the Early Ptolemaic Period*. University of Philadelphia, 1996 юм. Эртний Ромын татварын аж ахуйн талаар бичсэн дараах өгүүлэгийг мөн үзнэ үү, Gibbs Matt. "Tax farming", *The Encyclopedia of Ancient History*, ed. Roger S. Bagnall, Kai Brodersen, Craige B. Champion, and Andrew Erskine, London, Wiley-Blackwell, 2012.

³ Cizakca, Murat. "Tax-Farming and Resource Allocation in Past Islamic Societies." *Islamic Economics* 1, 1989, 59-80.

⁴ Stella, Peter. Tax Farming: A Radical Solution for Developing Country Tax Problems? *IMF Staff Papers*, 40-1, 1993, 217-225.

⁵ Azabou, Mongi and Nugent Jeffrey B. "Contractual Choice in Tax Collection Activities: Some Implications of the Experience with Tax Farming." *Journal of Institutional and Theoretical Economics (JITE) / Zeitschrift für die gesamte Staatswissenschaft* 144, no. 4, 1988, 684-705. Мөн Kiser, Edgar. "Markets and Hierarchies in Early Modern Tax Systems: A Principal-Agent. Analysis". *Politics and Society* 22, no. 3, 1994, 284-315.

⁶ Stella, Peter. Tax Farming: A Radical Solution for Developing Country Tax Problems? *IMF Staff Papers*, 40-1, 1993, 218.

⁷ Schurmann, Herbert F. *Economic Structure of the Yuan Dynasty: Translation of Chapters 93 and 94 of the Yuan shih*. Cambridge, Harvard University Press, 1956, 90.

мэхлэх ажиллагаа Ил хаант улсад газар авсан байсныг Рашид ал-Дин дурдсан байна⁸.

Энэхүү өгүүлэл нь монголчууд болон татвар хураах ажлыг түрээсээр эрхлэгчдийн хоорондын зөрчлийг агентын (төлөөллийн) онолын үүднээс тайлбарлах зорилготой. Ингэхдээ дундад зууны үеийн сурвалж, түүхийн шинжилгээ, орчин үеийн эдийн засгийн онол, судалгааны ажлуудад тулгуурлан монголчуудын ашиглаж байсан татварын түрээсийн гэрээний харилцаа, талуудын хооронд гарч байсан зөрчлийг тодруулна. Эл судалгаагаар татвар хураах түрээсийн тогтолцоо нь монголчуудын санхүү, тэдний эзлэгдсэн ард түмэнтэй харилцах харилцаанд аюул авчирч байсан тухай дурдах болно.

Түрээсийн гэрээгээр хурааж байсан татвар

Ихэнх гол сурвалж бичгүүдэд татварын түрээсийн талаар мэдээлэл төдийлөн хангалттай хэмжээнд байхгүй байна. Цагадайн улс болон Алтан Ордын түүхийн талаарх сурвалж маш хомс байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Оросын вант улсуудад алба гувчуурыг (*дань*) хурааж байсан исламын шүтлэгтэн хүмүүсийн талаар орос болон өрнөдийн сурвалжид өгүүлдэг⁹. Эдгээр хүмүүс нь жирийн даргач (*баскак*) эсвэл татварын түрээс эрхлэгч байсан эсэх талаар нотлох хангалттай баримт хараахан бидэнд олдоогүй байна. Ийм учраас Юань болон Ил хаант улсуудаас өмнөх үеийн татварын тогтолцооны талаар товч мэдээлэл гагцхүү Елюй Чуцайн булшны бичигт л үлджээ гэж дүгнэхэд буруутахгүй болов уу.

Цаасан мөнгөөр татвар хурааж байсан Юань улсад өрхийн болон газрын татварыг түрээсээр хураахыг хориглосон байдаг¹⁰. Харин Ил хаант улсад эртний исламын татварын орлого түрээслэх тогтолцоо буюу *мукама*-г ашигласаар байжээ¹¹. *Мукама* бол тухайн нэг татвар эсвэл хэд хэдэн нэр төрлийн татвар, хураамжийг цуглуулах орлогын түрээсийн хэлбэр юм. Тухайлбал, 1298 оноос Ширазыг 16 дүүрэгт хувааж, 80,000 динарыг цэргүүд, захиргааны ажилтнуудын цалин, тэтгэмжид, 1,000 динарыг үндсэн зардалд суутгах нөхцөлтэй гурван жилийн хугацаатай *мукама*-г олгох шийдвэр гарсан байдаг. 1319 оны орчим

⁸ Thackston, Wheeler M. *Rashiduddin Fazlullah's Jami' u't-tawarikh, A Compendium of Chronicles: A History of the Mongols, volume 3*. Cambridge, Harvard University, 1998-99, 727.

⁹ Halperin, Charles. *The Tatar Yoke: The Image of the Mongols in Medieval Russia, Corrected Edition* (Bloomington, Slavic Publishers, 2009), 82-87; Насонов Арсений Николаевич. *Монголы и Русь, История Татарской Политики на Руси*. Москва и Ленинград, Академия Наук СССР, 1940, 20, 52.

¹⁰ Schurmann, Herbert F. "Tributary Practices of the Thirteenth Century." *Harvard Journal of Asiatic Studies* 19, no. 3/4, 1956, 304-389.

¹¹ Lambton, Ann. *Continuity and Change in Medieval Persia*. New York, Suny Press, 1988, 121.

Фарс мужийн татварыг хураах байнгын *муката* гэрээг Ил хан Абу Са'ид өөрийн садангийн Курдужин хатанд соёрхсон байна¹². Дээрх хоёр үйл явдал нь шинэчлэл хийсэн Газан болон түүнээс хойш үед ч татварын түрээсийн хэлцэл үргэлжлэн хийгдсээр байсны илрэл юм.

Татварын бүх төрлийг эсвэл заримыг нь гэрээт татвар хураагчид хариуцаж байсан эсэх нь тодорхойгүй асуудал. Тодорхой үлдсэн нэг зүйл нь олон нэр төрлийн татвар, хураамжийг тэд хураадаг байсан явдал юм. Хааны сангийн орлогыг өсгөхийн тулд Монголын эзэнт гүрэнд 1238 оноос эхлэн татвар хураах хариуцлагыг хувь хүмүүст олгож эхэлсэн байна. Тухайлбал, Еньчинь дүүрэгт дарсны хураамж 50,000 лиань мөнгө хураах эрх авсан Лию Тиньюу, Хойд Хятадаас 500,000 лианийн хэмжээтэй албан татвар хураах эрх авсан Лию Кутурма, байшин, газар, өмч хөрөнгө, усжуулалтын ажил, гахай, шувууны аж ахуй зэргээс нийт 250,000 лианийн мөнгөн татвар хураах эрхтэй Сариф ал-Дин зэрэг хүмүүс татварын түрээс эрхлэгчдийн дунд нэр дурдагддаг¹³. Түүнчлэн нэгэн уйгур хүн 100,000 лиань дүнтэй давсны татвар хурааж өгөхөөр амлаж байжээ. Загасны аж ахуй, гүүр гэх мэт зүйлсээс хүртэл татвар хураах гэж хүмүүс өрсөлдөж байсан¹⁴. Зөвхөн энэ жишээнээс үзэхэд татварын түрээс нь олон төрлийн аж ахуй дээр ашиглагдаж байсан нь харагдаж байна.

Өгэдэйн үеэс ялгаатай нь Ил хаант улсад тухайн орон нутгаас хураах ёстой бараг бүх төрлийн татварыг татварын түрээс эрхлэгчид хариуцдаг байжээ. Тухайлбал XIII зууны сүүлээр Фарс мужийн эргийн зарим нутгийг Жамал ал-Дуала Малик ал-Ислам гэдэг чинээлэг худалдаачинд түрээслүүлжээ¹⁵. Ингэснээр Малик ал-Ислам тухайн орон нутгийн бүх төрлийн татварыг хураах эрхтэй болсон юм. Ил хаадын төрийн санд энэхүү Малик ал-Ислам орлогын зарим хэсгийг сувдаар төлж байсан байна.

Тооцоход илүү хялбар байдаг учраас эртний Азийн орнуудад газрын татвар зэрэг шууд татваруудыг татварын түрээсээр хурааж байсан байна¹⁶. Баруун Европт шууд бус татварыг хувь хүмүүс, байгууллагаар хураалгах нь түгээмэл байв. Харин

¹² Ann Lambton. "Wakf in Persia.", *The Encyclopaedia of Islam*, vol. XI: W-Z, ed. Bearman, Peri., Bianquis, Thierry., Bosworth, Edmund., Van Donzel., Heinrichs, Wolfhart. Leiden, Brill, 2002, 84. Мөн Lambton, Ann. *Continuity and Change in Medieval Persia*. New York, Suny Press, 1988, 275.

¹³ Buell, Paul D. "Cinqai". *In the Service of the Khan: Eminent Personalities of the Early Mongol-Yuan Period (1200–1300)*, ed. de Rachewiltz, Igor et al. Wiesbaden, Otto Harrassowitz, 1993, 98.

¹⁴ Schurmann, Herbert F. *Economic Structure of the Yuan Dynasty: Translation of Chapters 93 and 94 of the Yuan shih*. Cambridge, Harvard University Press, 1956, 90.

¹⁵ Lambton, Ann. *Continuity and Change in Medieval Persia*. New York, Suny Press, 1988, 336.

¹⁶ Ma, Jun. "New Public Management in the Early Modern Period: Lessons from Tax Farming History" *Administrative Theory & Praxis* 25, no. 4. 2003, 435-456.

Өгэдэй болон Ил хаадын үеийн сурвалжуудыг авч үзвэл монголчууд алба гувчуур зэрэг шууд болон тамга гэх мэт шууд бус татварыг хувийн гэрээт татвар хураагчдад хурааж авахыг зөвшөөрч байжээ. Энэ нь монголчуудад бэлэн мөнгөний асар их хэрэгцээ байсныг илтгэдэг.

Гэрээний төрөл

Татварын түрээсийн гэрээний гурван төрөл бий. Эхнийх нь тодорхой тохиролцсон мөнгөн дүнг төрд төлөх тогтмол дүнгийн гэрээ юм. Уг гэрээний дагуу хураасан орлогоос төрд төлөх тогтмол мөнгөн дүн, гарсан зардлыг хассан зөрүүгээс татварын түрээс эрхлэгч нь ашгаа олдог. Хоёр дахь нь хураасан орлогоос гэрээнд заасан тодорхой хувийг төртэй хуваалцах хэлбэр юм. Гурав дахь нь гэрээт татвар хураагчид тогтмол цалин олгодог гэрээ юм. Гэрээний төрлийн сонголт нь татвар хураагчийн үйлдлийг хянах төрийн хүчин чадал, эрсдэл хүлээх чадвараас хамаардаг. Харин татвар хураах түрээс эрхлэгч нь төрийн санал болгож байгаа гэрээний заалтад тулгуурлан өөрийн сэтгэл ханамжид суурилсан хамгийн их оновчтой төрлийг сонгон гүйцэтгэдэг байна.

Монголын хаад тогтсон мөнгөн дүнг төлүүлдэг эхний гэрээний хэлбэрийг хувийн татвар хураагчидтай байгуулж байсан. Тогтмол дүнгийн гэрээ нь дэлхийн улсуудад хамгийн их ашиглагдаж байсан гэрээний хэлбэр юм¹⁷. Тухайн газраас хурааж байгаа орлогоос татвар хураахад гарсан зардлыг төлүүлэхийг зөвшөөрч байв. Жишээ нь Ил хан Гайхатугийн төр барьсан үед Малик ал-Исламд Фарс мужийн эргийн нутгийг 4 жилийн хугацаатай, жилд 1.14 сая динарын зардал суутгах нөхцөлөөр 10 сая динараар түрээсэлсэн байна¹⁸. Нэг жилийн орлогыг Малик ал-Ислам урьдчилж төлсөн ба Ил ханд нэмж бэлэг сэлт барьжээ. Ил хаант улсад хасагдах зардлын төрөлд цэргийн зардал, харуул хамгаалалтын зардал, хэрэм, цайз сэргээх, барих зардал, тэтгэвэр, хүнсний зардал, хангамжийн зардал, өртөө яамын зардал, захиргааны ажилтнуудын цалинг оруулж байсан байна. Хасагдах зардлын төрөл тус бүрээр дүнг урьдчилж тохирдог байв¹⁹.

Онолын хувьд тогтмол дүнгийн гэрээний дагуу төрийн орлого баталгаажиж, санхүүгийн эрсдэл хувийн салбарт шилждэг байсан байна. Ингэж эрсдэл үүрснийхээ төлөө тогтмол мөнгөн дүнгийн гэрээг байгуулсан татварын түрээс

¹⁷ Ma, Jun. "New Public Management in the Early Modern Period: Lessons from Tax Farming History" *Administrative Theory & Praxis* 25, no. 4. 2003, 442.

¹⁸ Lambton, Ann. *Continuity and Change in Medieval Persia*. New York, Suny Press, 1988, 336.

¹⁹ Lambton, Ann K. Mongol Fiscal Administration in Persia (Part II). *Studia Islamica*, No. 65, 1987, 97-123.

эрхлэгч орлогоо зардлаас давуулж, ашгаа хамгийн их болгох зорилгоор ажилладаг байжээ. Татвар хураах ажлыг түрээсээр эрхлэгчийн хамгийн их ашиг олох түвшин бол өөрийнхөө ахиуц орлогыг ахиуц зардалтай тэнцүү байлгах явдал юм. Иймээс хурааж байсан татварын хэмжээг нэмэгдүүлж чадаагүй тохиолдолд татварын түрээс эрхлэгчид өөрсдөө их хэмжээний алдагдалд ордог байв.

Монголын эзэнт гүрэнд татварын түрээсийн гэрээг богино хугацаатай байгуулж байсан байна. Тухайлбал, *Юань улсын судар*-т Хойд Хятадын жилийн орлогыг нэг жилийн дотор хоёр дахин өсгөх амлалтыг Абд ал-Рахман өгсөн байна²⁰. Ийм богино хугацаатай гэрээ нь хувийн салбарын богино хугацаанд хурдан ашиг олох гэсэн эрмэлзлийг нэмэгдүүлж байжээ. Өндөр дүнтэй татварын орлого хураахыг амлаж, түрээслэх эрх авсан гэрээт татвар хураагчид их ашиг олохын тулд түрэмгий үйлдлүүд их гаргадаг байсан байна. Үүнээс болж урт хугацаанд төрийн орлого болон тухайн газрын бүтээмж багасах зэрэг хор хөнөөл гарч байжээ²¹. Богино хугацааны зорилтыг тавих үед татварын түрээс эрхлэгч бага өртгөөр хурдан орлого олох арга замыг илүүд үздэг байсан нь ойлгомжтой. Урт хугацаанд үнэ цэнэ бүтээх үйл явцад богино хугацааны зорилтууд үнэхээр хор уршигтай байдаг уу гэдэг асуудал маргаан дагуулдаг. Богино хугацааны үр ашгийг харахаас зайлсхийх нэг хэлбэр нь гүйцэтгэгч талын төлбөрийг урт хугацааны үр дүнтэй уялдуулах явдал юм²². Монголчууд ийм аргыг ашиглаж байсан хангалттай нотолгоо олдоогүй байна. Учир нь татварын түрээс эрхлэгчдийн байр суурь тухайн үеийн улс төрийн байдлаас бүрэн хамааралтай байв. Ил хаадын улсад татвар хураах ажлын түрээсийн гэрээг нэгээс дээш жилийн хугацаатай байгуулж байсан боловч улс төрийн эрсдэл гэрээний тогтвортой байдалд эрсдэл учруулж байсан байна. Татварын түрээс эрхлэгчдийн байр суурь нэг удирдагч нөгөөгөөр солигдоход аюулд ордог байсан байна. Ингэснээр татвар хураахаар урт хугацаат гэрээ авсан хүн дараагийн хааны хүслээр хурдан солигдох өндөр магадлалтай байсан юм.

Гэрээний аливаа хэлбэр нь ашиг сонирхлын зөрчлийн нэг хэлбэрээс сэргийлэх боловч өөр бусад хэлбэрийн зөрчлийг бий болгодог эрсдэлтэй. Дэлхийн түүхэн баримтуудаас харахад тогтмол дүнгийн гэрээ нь татварын түрээс эрхлэгчдийг

²⁰ 元史, 第二章 . 北京市, 中华书局出版社, 1976, 36.

²¹ Ma, Jun. "New Public Management in the Early Modern Period: Lessons from Tax Farming History" *Administrative Theory & Praxis* 25, no. 4. 2003, 439.

²² Narayanan, M. P. "Form of Compensation and Managerial Decision Horizon". *The Journal of Financial and Quantitative Analysis*, no. 31, 1996, 467-491. Мөн Jackson, Gregory., Petraki, Anastasia. *Understanding the Short-termism: Corporate Governance*. Stockholm, Glasshouse Forum, 2011.

татварыг хэтрүүлэн хураахыг өдөөдөг гол шалтгаан болж байсан байна.²³ Тогтмол дүнгийн гэрээний үед татварын түрээс эрхлэгчийн хураасан орлого нь төрд төлөх төлбөр хийгээд гаргасан үйл ажиллагааны зардлаас их байх ёстой. Энэ нь тэднийг орлогыг ихэсгэхийн тулд татвар хураалтыг харгис хэрцгийгээр явуулахад хүргэж байсан. Мөн худалдаачид татварын төлбөрийг барагдуулахад нь зориулж татвар төлөгчдөд өндөр хүүтэй зээл олгодог байсан байна.

Татварын түрээсийн дарамт нь хор хөнөөл ихтэй байсан тул улс төрийн тогтворгүй байдал үүсгэх, монголчуудын захиргааг эсэргүүцсэн бослого, хөдөлгөөн гарах аюултай байсан. Татварын түрээс эрхлэгчдийн харгис үйлдэл нь зарим тохиолдолд цус урсгасан бослого гарахад хүргэж байжээ. 1262 онд Ростов, Владимир, Суздаль, Ярославль хотын оршин суугчид исламын шүтлэгтэй (*бесермен*) татварын түрээс эрхлэгчдийг хөөсөн байна.²⁴ Владимир, Устюг, Ростов болон бусад том хотуудад гарсан бослогын улмаас зарим татвар хураагчид амь насаа хүртэл алдаж байжээ. Хураах ёстой байсан татварын орлогыг хэт өндөр тооцсон учраас татварын хураах ажлыг түрээсээр эрхлэгчид төрд амласан төлбөрөө өгч чадахгүйд хүрэх тохиолдол гарч байв. Хамгийн аюултай нь татварын түрээсийн харгис үйл ажиллагаа эдийн засгийн бүтээмжийг урт хугацаанд уналтад оруулах эрсдэлтэй байлаа. Энэхүү зөрчлийн талаар дараагийн хэсэгт авч үзье.

Монголчууд болон татварын түрээс эрхлэгчдийн хоорондын зөрчил

Агент болон эзэн хоёрын хоорондын зөрчлийн онол нь эрсдэлийн хуваарилалт, гэрээнд тулгуурласан байдаг. Уг онолд бизнесийн харилцаанд гарч буй эзэн, агентын зорилго, ашиг сонирхлын зөрчил, тэдний харилцан ялгаатай эрсдэл үүрэх чадвараас бий болсон асуудлыг авч үздэг. Хувь хүмүүсээр татвар хураалгах гэрээнд эзэн нь төр (жишээ нь их хаан эсвэл Ил-хаадын улсын засаг захиргаа), агент нь татварын түрээс эрхлэгч юм. Эзний нэрийн өмнөөс агент гэрээгээр тохирсон үйл ажиллагааг явуулах үед агентын зардал үүсэж болзошгүй байдаг. Энэхүү гэрээ байгуулагдсаны дараа татварын түрээс эрхлэгчийн зүгээс учруулж болзошгүй сөрөг үйлдэл бол ёс суртахууны асуудал юм.

Агентын зардал нь эзэн, агент хоорондын ашиг сонирхлын зөрчил ихсэх тусам өсдөг. Тухайлбал эзэн нь бизнесийг үр ашигтай, эрсдэл багатай байлгахыг хүсэж

²³ Sungkyu Jang, *Three Essays on Tax Collection: A Historical Review, A Formal Model, and an Empirical Test of the Government's Contractual Choice of Tax Collection Between Tax Farming and Tax Bureaucracy*. Tallahassee, The Florida State University, 2012.

²⁴ Насонов Арсений Николаевич. *Монголы и Русь: История Татарской Политики на Руси*. Москва и Ленинград, Академия Наук СССР, 1940, 220.

байхад агент өөр зорилго өвөрлөн үр ашиг багатай үйл ажиллагаанд хөрөнгө, хүч зарцуулах хандлагатай байж болно. Эзний зүгээс агентын үйл ажиллагааг байнга хянах боломжгүй тул агентын зардал ихсэх эрсдэлтэй байдаг. Иймээс уг дотоод зардлыг бууруулахын тулд гэрээний хэлбэр, урамшууллыг зөв сонгох нь чухал болно. Нөгөө талаас гэрээ байгуулахаас өмнө эсвэл байгуулж байх үед буруу сонголт гарч болзошгүй юм. Буруу сонголт нь арилжаанд оролцогч талуудын хооронд мэдээллийн тэгш бус байдал оршиж байгаа үед гардаг. Зарж байгаа зүйлийн талаар борлуулагч мэдээлэлтэй, харин худалдан авагч мэдэхгүй байх үед худалдан авагч буруу сонголт хийх магадлал өндөр байдаг. Энэ нь төр, татварын түрээс эрхлэгч хоёрын алинд нь ч учрах боломжтой тул эрсдэл ихтэй гэсэн үг.

Татварын түрээс бол улсад төлөх татварын тодорхой төрлүүдийг хураах эрхийг хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд дуудлага худалдаагаар арилждаг тогтолцоо гэж Стелла тодорхойлсон байна²⁵. Хэрэв амжилттай хэрэгжвэл татварын түрээсийн гэрээгээр улсын орлого өсөх боломжтой юм. Гэрээт татвар хураагчийн ашиг нь бодит хураасан орлого болон улсад төлөх татварын орлогын дүн, татвар хураахад гаргасан зардлын зөрүүгээр тодорхойлогдож байв. Иймд тухайн газар, хүн амаас хураах боломжит татварын дээд хэмжээг бодит байдлаас хэтрүүлэн төрд амлавал их хэмжээний алдагдалд орох эрсдэлтэй нь мэдээж. Татварын түрээс эрхлэгч их хэмжээний алдагдалд орохоос гадна бүр үгээгүй ядуурах ч явдал гарч байсан. 1277 онд Фарс мужийн татвараас олох орлогыг түрээслэх гэрээг Ил хаадын засгийн газартай баян худалдаачин Шамс ал-Дин Мухаммад байгуулжээ. Хугацаандаа татвараа төлж чадаагүйн улмаас 10 жилийн дотор Шамс ал-Дини эд хөрөнгө шавхагдаж, 1299 он гэхэд ядуурч тарчиг амьдрах болсон аж²⁶. Хувь хүмүүс төрд төлөх ёстой татварын орлогоос гадна бүх зардлыг өөрөө хариуцаж байсан учир татварын түрээсийн гэрээний дагуу төр эрсдэлээ хувийн гэрээт татвар хураагчдад шилжүүлж байжээ.

Зарчмын хувьд татварын түрээсийн үйл ажиллагаа төрийн хяналт дор байсан. Тухайн газрын орлогыг хүн амын бүртгэлтэй тулгаж харьцуулдаг, татварын түрээс эрхлэгчийн хураасан татвар болон зардлыг шалгадаг, улсын татварын авлагыг тооцдог байжээ. Мөн татвар төлөгчдөөс монголчуудад ирэх гомдол татварын түрээслэх явцад тавих зах зээлийн хяналт болж байв. Татвар төлөгчдийн санал, гомдлыг ашиглаж чадах нь тухайн газрын захирагч, даргач нарын ёс зүйгээс их

²⁵ Stella, Peter. Tax Farming: A Radical Solution for Developing Country Tax Problems? *IMF Staff Papers*, 40-1, 1993, 220.

²⁶ Lambton, Ann K. Mongol Fiscal Administration in Persia (Part II). *Studia Islamica*, No. 65, 1987, 101.

хамаарч байсан. Ил хаант улсад төрөөс тогтоосон хэмжээнээс илүү эсвэл бага хэмжээгээр албан татвар хураах, шинэ төрлийн хураамж оногдуулахыг хориглож байжээ²⁷. Бодит амьдрал дээр улсаас тавих хяналт сул байсан учраас ард түмнээс хэт их алба гувчуурыг татварын түрээс эрхлэгчид цуглуулж, татварыг давхардуулах зэрэг олон зохисгүй үйлдэл гаргаж байсан. Ялангуяа ийм явдал Хүлэгүгийн үр удмын гишүүдийн хооронд болж байсан улс төрийн тогтворгүй үе болох 1282 оноос 1295 оны хооронд ихэссэн байна²⁸.

Татвар хураах явдал татварын түрээс эрхлэгчдэд ч бас үйл ажиллагааны зардал ихтэй ажил байсан юм. Монголын эзэнт гүрний хувьд олон тооны гэрээт татвар хураагчдыг татварын түрээс эрхлэгчид хөлсөлж байсан нь гарцаагүй. Дэлхийн улсуудын жишээн дээр харахад татвар хураах үйл ажиллагаанд олон хүнийг энэ ажилд хамруулдаг байв. Ж. Б. Коллинзийн тооцоогоор XVII зууны Францад насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 2-оос 3 хувь нь жил бүр татвар хураах тогтолцоонд ажилладаг байжээ²⁹. Эртний Ромд хэдэн арван мянган хүн шууд болон шууд бус татварын орлого хураах нүсэр ажилд дайчлагдаж байв. Нэгэн жишээн дээр татварын түрээсийн захиргааны ажилчид, хамгаалагчдын цалинг нийт хасагдах зардлын дүнгийн 5 гаруй хувиар ил-хааны засаг захиргаанаас тогтоож байжээ³⁰. Мөн Ил хаант улсад том мужийн татвар хураах эрх авсан хувь хүн тухайн газар нутгийг дотор нь задалж, татварын түрээсийн олон дэд гэрээг бусад хүмүүстэй байгуулж байжээ. Олон дэд гэрээнүүдийг хянах нь татварын түрээс эрхлэгчийн зардлыг өсгөж байсан. Иймээс зардлыг бууруулах хамгийн хялбар гэхдээ улсад хортой арга нь дэд гэрээнүүдэд төрийн хатуу хяналтыг бууруулах явдал юм. Үүний улмаас Ил хаант улсад гэрээт татвар хураагчид эрхээ хэтрүүлэн ашиглах болсон байна. Ил хааны засгийн газар *мукама*-гийн дотоод санхүүгийн үйл ажиллагаанд тэр бүр оролцдоггүй байжээ. Гол шалтгаан нь хүн ам ихтэй, өргөн уудам газар нутгийг хянахад хүн хүч, санхүүгийн нөөц Ил хаадад хангалтгүй байсан явдал юм. Гэхдээ шаардлагатай үед улсаас төлөөлөгч илгээж шалгадаг байжээ. Тэдгээр түшмэд орон нутгийн санхүү, төсвийн алдааг засаж залруулах, засгийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлдэг байв.

²⁷ Lambton, Ann K. Mongol Fiscal Administration in Persia (Part II). *Studia Islamica*, No. 65, 1987, 100.

²⁸ Lambton, Ann K. Mongol Fiscal Administration in Persia (Part II). *Studia Islamica*, No. 65, 1987, 97-123.

²⁹ Collins, James B. *Fiscal Limits of Absolutism: Direct Taxation in Early Seventeenth Century France*. Los Angeles and London, University of California Press, 1988, 16.

³⁰ Lambton, Ann K. Mongol Fiscal Administration in Persia (Part II). *Studia Islamica*, No. 65, 1987, 100.

Төрөөс урьдчилан зөвшөөрөл авсны дараа хураасан орлогоос гарсан зардлаа суутгаад, илүү гарсан дүнгээс нь улсад төлөх төлбөр, төрийн нэхэмжилсэн нэмэлт зардлыг татварын түрээс эрхлэгчид төлж байв³¹. Татварын түрээс эрхлэгчид, орон нутгийн түшмэд болон *хаким*-ууд (захирагч) төрд төлөх нэрийдлээр алба гувчуур хурааж хөрөнгийг хувьдаа ашиглан, улсад төлдөггүй тохиолдол олон гарч байв³². Ийм шалтгаанаар тодорхой хугацаанд орлого тушаах гэрээтэй татвар хураагчид улсын орлогыг төлөхгүй хойшлуулсаар байсан тул зарим мужаас ирэх улсын орлого тасалдаж байжээ. Хэрэв татварын түрээс эрхлэгчийн тушаасан орлого улсад төлөх ёстой татварын хэмжээнд хүрээгүй бол дутуу дүнг түүний хугацаа хэтэрсэн өглөгт шилжүүлж тооцдог байсан.

Татварын түрээсийг Хубилай халж, Ил хаант улсад Газаныг хүртэл үргэлжилсэн гэж Х. Ф. Шурманн үзсэн байдаг³³. Түүний үзсэнээр төсөв, санхүүгийн тогтолцоо сайтар хөгжөөгүй үедээ монголчууд татварын түрээсийг өргөн ашиглаж байсан байна. Харин татварын түрээс цаашид Алтан Ордны улсад илүү хөгжсөн гэж А. П. Мартинез үзжээ³⁴. Түүхийн баримтуудыг нягталж үзвэл түүний энэхүү онол бодит байдалтай тэр бүр нийцэхгүй юм. Татварын түрээсийг өрхийн болон газрын татварын тогтолцооноос халахын тулд байнгын татварын тогтолцоог Хубилай хаан Юань гүрэнд бий болгосон байна³⁵. 1291 онд буй нэгэн баримтад газрын татварын түрээсийг төрийн түшмэд, бичээч, хүчирхэг, баян хүмүүс эрхэлж болохгүй гэж зарлигдсан байдаг. Энэ нь Юань улсад мөнгөний тогтолцоо харьцангуй боловсронгуй болж, төрийн санхүүгийн удирдлага сайтар хөгжсөнтэй холбоотой юм. Гэхдээ онцгой түүхий эд дээр татварын түрээс ашиглагдсаар байжээ. Тухайлбал, 1316-аас 1318 онуудад Хэнань мужийн мөнгөний уурхайнуудаас татвар хураах асуудлыг Ли Юнчи, Ли Кюэй болон бусад хувь хүмүүст хариуцуулсан байдаг³⁶.

³¹ Lambton, Ann K. *Mongol Fiscal Administration in Persia (Part II)*. *Studia Islamica*, No. 65, 1987, 100, 108.

³² Thackston, Wheeler M. *Rashiduddin Fazlullah's Jami' u't-tawarikh, A Compendium of Chronicles: A History of the Mongols*. volume 3. Cambridge, Harvard University, 1998-99, 727.

³³ Schurmann, Herbert F. "Tributary Practices of the Thirteenth Century." *Harvard Journal of Asiatic Studies* 19, no. 3/4, 1956, 368.

³⁴ Martinez, Arsenio Peter. "Institutional Development, Revenues and Trade". *The Cambridge History of Inner Asia: The Chinggisid Age*. Cambridge, Cambridge University Press, 2009, 99.

³⁵ Morris Rossabi, *Khubilai Khan: His Life and Times*. Berkeley, University of California Press, 1988, 121.

³⁶ Schurmann, Herbert F. *Economic Structure of the Yuan Dynasty: Translation of Chapters 93 and 94 of the Yuan shih*. Cambridge, Harvard University Press, 1956, 156.

Ил хаант улсын хааны сан нь татварын түрээснээс ихээхэн хамааралтай байв. Хүлэгүгийн гэр бүл худалдаачдад худалдаа, арилжаагаа хийх илүү таатай орчинг өөрсдийн нутагт дэвсгэр дээрээ бүрдүүлж өгсөн байдаг. Татварын түрээс эрхлэгчид мөнгө ихтэй чинээлэг байсан тул үе үеийн хаан, язгууртнууд тэднээс мөнгө зээлдэг байв. 1259 онд Гүржид том хэмжээний бослого гарсан нь Иран гаралтай татварын түрээс эрхлэгч Хожа Азизын учруулсан дарамттай холбоотой байв³⁷. Гэвч өөрийн хаан ахаас ялгаатай нь Хүлэгү татварын түрээсийг улс даяар зогсоосонгүй. Энэ явдлаас хойш ч Ил хаант улсын бусад чинээлэг хэсэг болох Фарс, Кирман, Ирак зэрэг мужуудад татварын түрээс оршсоор байв. Орон нутгийн *хаким*-ууд татвар хураах эрхийг эзэмших болсон байна. Тэдний дунд газрын эзэд, худалдаачид, нөлөө бүхий хувь хүмүүс зонхилж байсан бөгөөд ихэнхдээ албан тушаалыг худалдан авдаг байв.

Вассафын мэдээллээс үзвэл дээрх хүмүүсээс гадна цэргийн ноёд, *хаким*-ууд бас *мука*та гэрээг эзэмшигч эсвэл дэд гэрээлэгчид болж байжээ³⁸. Тэдгээр татварын түрээс эрхлэгчдийн дунд хуучны нөлөө бүхий гэр бүл ч багтаж байв. Тухайлбал, 1282 оноос эхлэн Кирманы нөлөө бүхий гэр бүл Кутлуг ханууд *мука*та-г эрхэлж байжээ. Гүйлгээнд гарсан мөнгөний хэмжээ XIII зууны сүүлээс нэмэгдсэн ч татварын түрээсийн хэрэгцээ Ойрх Дорнодод өссөн. Хүлэгүгийн залгамжлагчдын сангийн хөрөнгө, орлого буурах тусам төрийн санхүү татварын түрээснээс улам бүр хамааралтай болж байв. Рашид ал-Дины бичсэнээр Хүлэгүгийн аян дайны олзыг Салас, Урмиа нуурын дэргэд Теллэ нэрт уулан дээр том цамхаг барьж хадгалсан байна³⁹. Хожим цамхгийн нэг хэсэг нурж, хараа хяналт суларснаар түүнд хадгалсан байсан эрдэнэс, хөрөнгө 1283 он гэхэд үрэгдэж дууссан байна.

Хувь хүмүүст татвар хураах эрхийг шилжүүлсэн нь төрийн хяналт, хариуцлага тооцох тогтолцоо үгүй болсон гэсэн үг хараахан биш юм. Монголчууд доголдол гаргасан татварын түрээстэй хариуцлага тооцож байсан талаар хэд хэдэн баримт бий. Татварын түрээс байгуулсан гэрээг шаардлагатай үед цуцлах эрхтэй байжээ. 1279 онд Иранд *мука*та-г цуцлаж, татварын орлогыг удаан хугацаанд хоцроосон этгээдүүдийг шоронд хорьсон байдаг⁴⁰. Татварын түрээс эрхлэгч хариуцлага

³⁷ Греков, Борис Дмитриевич., Сидоров, Аркадий Лаврович. *Очерки Историй СССР 14-15 вв.* Москва, Академия Наук СССР, 1953, 698-699.

³⁸ Lambton, Ann K. *Mongol Fiscal Administration in Persia (Part I).* *Studia Islamica*, No. 64, 1986, 79-82 ба 98.

³⁹ Thackston, Wheeler M. *Rashiduddin Fazlullah's Jami 'u't-tawarikh, A Compendium of Chronicles: A History of the Mongol.* volume 3. Cambridge, Harvard University, 1998-99, 659.

⁴⁰ Lane, George. *Early Mongol Rule in Thirteenth-Century Iran: A Persian Renaissance.* London and New York, Routledge Curzon, 2003, 139.

алдаж, ашиг сонирхлын зөрчлийн улмаас эрхээ хэтрүүлсний хамгийн хүнд шийтгэл нь цаазын ял байв. 1262 онд дээр дурьдсан Хожа Азизыг цаазалж байж Гүржийн бослого сая намжсан байдаг. Энэ хэрэг явдлын дараа Монголын захиргаа өмнөд Кавказад дахин сэргэсэн ч Гүржийн вант улс хэрэг дээрээ хоёр хуваагдсан юм. Тбилисийн хаан Ил ханы шууд захиргаанд орж, арай жижиг газар нутгийг захирч байсан Кутаиси төвтэй Абхазын гүржүүд харьцангуй бие даах болжээ. Абхазыг эзлэх гэсэн Хүлэгү болон түүний залгамжлагч Абага нарын оролдлого бүтэлгүйтсэн юм⁴¹. Дөнгөж 1330 онд Гүржийн вант улс дахин нэгдсэн байна. Энэ бол Ил хаант улс бутрахаас 5 жилийн өмнө болсон явдал байв.

Татварын түрээсийн гэрээтэй холбоотой гарч байсан өөр асуудал бол гэрээний буруу сонголт юм. Төр, хувийн салбарын аль аль нь буруу сонголтыг хийх тохиолдол байсан. Татварын түрээсийн хувьд хамгийн өндөр орлогыг санал болгосон этгээдтэй төрөөс гэрээ байгуулж байсан учраас хэд хэдэн эрсдэлтэй байв. Хүлээгдэж буй орлогыг татварын түрээс эрхлэгч хэт өндөр тооцох эсвэл өөрийнх нь төрд санал болгосон дүн, гаргах зардлын дүнгээс тухайн газраас хураах татварын орлого бага байх тохиолдол гарч байсан. Өөрөөр хэлбэл татварын түрээс эрхлэгч ашигтай ажилласан ч төлөвлөж байсан орлого бага байснаар түүний сэтгэл ханамж хангалтгүй байх явдал юм. Нөгөө талаас хураасан бодит орлого нь гаргасан зардлаас бага байгаа учраас хувийн салбар санхүүгийн хувьд бүрэн алдагдал хүлээдэг байсан байна. Иймээс эцэст нь орлогыг хэт өндөр үнэлсэн тал дуудлага худалдаанд ялах боломжтой юм. Үүнийг эдийн засгийн шинжлэх ухаанд *ялагчийн хараал* гэж нэрлэдэг. Тухайн газрын эдийн засгийн бүтээмжийн талаар бүрэн мэдээлэлгүй байх, сэтгэл хөдлөл (жишээ нь орлогын талаар хэт өөдрөг төсөөлөл), өрсөлдөөн гэх мэт олон хүчин зүйлс үүний шалтгаан болдог. Хураах орлогыг үнэ хаялцуулсны улмаас их хэмжээний мөнгөн төлбөрийг төрд тушаах ёстой болдог байсан нь эцэстээ татвар төлөгчдийн үүрэх дарамтыг ихэсгэдэг байв. Ил хаант улсад татварын тогтсон хувийг зөрчихийг хатуу хориглож байсан боловч татварын түрээс эрхлэгчид зардлаа нөхөхийн тулд хэт өндөр хэмжээний татвар, хураамж иргэдээс гаргуулж авсаар байжээ. Түүнчлэн татварын түрээс эрхлэгчийг төр буруу сонгох эрсдэлтэй байдаг. Дуудлага худалдаа, улсын санхүүгийн хүндрэл, улс төрийн ашиг сонирхлын улмаас чадвар бага, хүчин чадавх муутай татварын түрээс эрхлэгчийг сонгож, гэрээ байгуулах тохиолдол гарч байв. Энэхүү буруу

⁴¹ Müller, Christian., Pahlitzsch, Johannes. "Sultan Baybars I and the Georgians: In the Light of New Documents Related to the Monastery of the Holy Cross in Jerusalem." *Arabica* 51, no. 3, 2004, 258-290.

сонголтын нийгмийн зардал их байв. Үүний улмаас улсын орлого буурах, тухайн газрын эдийн засгийн бүтээмж багасах, чадварлаг татварын түрээс эрхлэгчид сонгогдохгүй байх, хүмүүсийн амьжиргааны түвшин дордох, бослого гарах зэрэг хорт үр дагаврууд гарч байсан.

Ёс суртахууны аюул болон буруу сонголтыг 1230-аад оны нэгэн жишээн дээр дэлгэрэнгүй авч үзье. Татварын түрээсийг хятад болон хятан түшмэдүүд анхнаас нь эсэргүүцсээр ирсэн байдаг. Өгэдэй хааны үед олон хүнд татвар хураах эрхийг зарсанталаар эхний хэсэгт дурдсан. Татварын түрээсийн гэрээ олгохыг болиулахаар Елюй Чуцай хааныг ятгаж байсан байна. Гэвч Дундад Азийн худалдаачдын нөлөө төрд улам бүр нэмэгдсээр байв. Хааны гол сайд Чинхай дэмжээний дагуу 1240 онд Абд ал-Рахман гэдэг нэртэй хүнийг Хойд Хятадад татварын түрээс эрхлүүлэхээр томилсон байна. Улсад санхүүгийн нөөцийн хэрэгцээ их байсан тул хамгийн өндөр орлогыг хураахаар санал болгосон хүнд давуу талыг олгож байв. Абд ал-Рахман бол исламын шүтлэгтэн, худалдаачин хүн байсан юм. Татварын түрээсээс болж төрийн засаглал суларч, ард түмэнд их хэмжээний дарамт учрах болно хэмээн Елюй Чуцай эсэргүүцсэн байна. Харин энэ удаа түүний саналыг Өгэдэй хаан хүлээн авсангүй. Удалгүй Абд ал-Рахманд Монголын захиргаанд байгаа Хятад дахь татвар хураадаг бүх хэлтсийг хариуцуулжээ.

Хойд Хятадаас хураах орлогын хэмжээ 1234 онд тогтоосон хэмжээнээс хоёр дахин нэмэгдэж, 44,000 мөнгөн өмбүүнд хүрсэн байна. Монголчууд хүний тоо, мал, хөрөнгөнд оногдуулсан татварын хувь хэмжээнээс гадна муж, тосгоноос хураах татварын хэмжээг тогтоодог байсан. Жишээлбэл, Оросын жижигхэн тосгон, гацаа хүртэл 650-аас 900 граммын мөнгийг тогтмол төлөх ёстой байв. Энэхүү татварыг төлөхийн тулд хөдөөгийн тосгонууд гаднаас мөнгийг илүүдэл хөдөө аж ахуй, ангийн бүтээгдэхүүнээр сольж авч байсан⁴². Улсаас тогтоосон татварын хэмжээг бууруулах тал дээр зарим үед нөлөө бүхий алтан ургийн гишүүд, ноёд, тэдний холбоотон орон нутгийн нөлөө бүхий хүмүүс амжилт олсон байна. Тухайлбал, Херат дахь нэгэн хүчирхэг түшмэдийн албатууд, Хубилайн хувь эзэмшил Хонанд татвараас зайлсхийх, хувь хэмжээг бууруулах явдал гарсан. Хойд Хятадад татварын орлогын хэмжээг өсгөхдөө Абд ал-Рахман орон нутгийн эдийн засгийн байдлыг хэт өөдрөг төсөөлж, хүлээгдэж буй өгөөжийг хэт өндөр тооцсон байна. Ингэж өндөр тооцох болсон нь тухайн цаг үеийн Хятадын эдийн засгийн байдалтай холбоотой юм. Хятад нь эрт цагаас баян тансаг байдлаар олон улсад алдартай. Эдийн засгийн

⁴² Halperin, Charles J. *Russia and the Golden Horde: The Mongol Impact on Medieval Russian History*. Bloomington, Indiana University Press, 1987, 84.

түүхч А. Мэддисоны тооцоогоор Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүн 1990 оны зэрэгцүүлэх үнээр манай эриний 1000 онд 26.5 тэрбум олон улсын долларт хүрч байсан нь баруун Азийн улсуудаас 2 дахин, европоос 1.9 дахин их байжээ⁴³. Гэвч тухайн цагт Монголын захиргаанд байсан Хятадын газар нутаг нь Монгол-Алтан улсын дайны хор уршгаас бүрэн сэргэж амжаагүй байв. Хойд Хятадад шинээр тогтоосон татварын хэмжээ нь оновчтой түвшингээсээ хэтэрсэн байсан нь Елюй Чуцайн өргөн барьсан айлтгалаас тод харагддаг. Тухайн үед 22,000 ембүү байсан татварын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэхийн тулд төрийн хатуу хууль цааз хэрэглэх ёстой болох бөгөөд үүний улмаас ард түмэн үгээгүй ядуурч, гэмт хэрэг нэмэгдэх болно гэж тэр анхааруулж байжээ⁴⁴. Өмнө нь Хятадад (үнэт металл) мөнгөөр татвар төлдөггүй байсан тул Өгэдэйн засгийн газрын төсвийн шинэчлэл мөнгөний эрэлтийг огцом өсгөжээ. Энэ нь тэндхийн иргэдэд бас нэгэн дарамт болсон юм. Татварын түрээсийн дуудлага худалдаагаар татварын хэмжээ хэт өндөр тогтсон байсан тул хятадын татвар төлөгчид худалдаачдаас зээлж татварын төлбөрийг барагдуулж байв. Монголчуудын дэмжлэгтэйгээр давуу эрх эдэлж байсан ортаг худалдаачид тэдэнд маш өндөр хүүтэй зээл олгож байсан юм⁴⁵. Хүн хүчний хувьд хүрэлцээгүй байсан учраас монголчууд тэдний үйл ажиллагааг хянах боломжгүй байв. Нөгөө талаас эзэд өөрсдөө ажил гүйцэтгэгчийг тэдний ашиг сонирхлын эсрэг үйлдэл гаргахад шууд бусаар нөлөөлдөг. Монголчууд хамгийн их татварын орлого хураахыг амласан хүнд татварын түрээс эрхлэх зөвшөөрөл богино хугацаатай өгч байсан нь түргэн хугацаанд орлого их олох гэсэн хувийн салбарын эрмэлзлийг дэврээсэн байна.

Удалгүй хойд Хятадад нөхцөл байдал хүндэрч эхэлсэн. Хятадын иргэд татварыг төлөхийн тулд эд хөрөнгө, эхнэр, хүүхдээ хүртэл зарахад хүрчээ⁴⁶. Зарим хүмүүс харьяа газар, нутгаа хаяж зугтсан байна. Юань улсын сударт тухайн цаг үеийг ингэж дүрсэлжээ:

“Энэ жил албан татвар төлөхийн тулд барууны алтыг түшмэдүүд болон ардууд зээлсэн учраас жилд зээлсэн дүн нь хоёр дахин нэмэгдсэн. Үүнийг хурган

⁴³ Maddison, Angus. *Contours of the World Economy, 1–2030 AD: Essays in Macro-Economic History*. Oxford, Oxford University Press, 2007, 379.

⁴⁴ Rachewiltz, Igor de. “Yeh-lü Ch’u-ts’ai, Yeh-lü Chu, Yeh-lü Hsi-liang”. *In the Service of the Khan: Eminent Personalities of the Early Mongol-Yuan Period (1200–1300)*, ed. Igor de Rachewiltz et al. Wiesbaden, Otto Harrassowitz, 1993, 136–175.

⁴⁵ Allsen, Thomas T. “Mongolian Princes and Their Merchant Partners, 1200-1260”. *Asia Major* 2, no. 2. 1989, 102-103.

⁴⁶ Allsen, Thomas T. “Mongolian Princes and Their Merchant Partners, 1200-1260”. *Asia Major* 2, no. 2. 1989, 104.

хүү гэж нэрлэдэг. Учруулсан хор хөнөөл нь ноцтой байсан. Улсын мөнгөөр өрийн үлдэгдлийн эргэн төлөлтийг хийх хааны зарлиг гарсан. Бүгд нийлээд 76,000 ембүүнд хүрсэн байна. Бас олон жилийн хугацаатай олгосон зээлийн хүүгийн хэмжээ үндсэн төлбөртэй тэнцүү байх ёстой бөгөөд түүнээс дээш өсөхгүй гэж зарлиг буулгажээ.”⁴⁷

Тогтсон татварын хэмжээг өрийн үлдэгдэлтэй харьцуулахад өрийн дарамт их болсон нь мэдэгдэж байна. Монголын засгийн газраас худалдаачдын зарцуулсан хөрөнгө оруулалтыг бүрэн төлж, хүүгийн түвшинг 100% хүртэл бодож нөхөн төлсөн улсын санд их хохиролтой байсан. Яагаад Өгэдэй хаан ийм шийдвэр гаргахад хүрсэн бэ? Абд ал-Рахман бол Өгэдэй болон түүний хатан Дөрэгэнэтэй маш ойр дотно хүн байсан. Гэвч хаан, албат хоёрын энэ нөхөрсөг харьцаа үүний гол шалтгаан биш байсан юм. Худалдаачдыг дэмжих Монголын төрийн бодлого ч үүнтэй хамаагүй байжээ. Зээлийн хямрал цааш газар авч магадгүй байсан нь хааны санааг хамгийн ихээр зовоож байв.

Худалдаа, татварын түрээсийн ашиг нь нийгмийн дээд давхаргын гишүүдийн сонирхлыг соронзон мэт хүчтэй татаж байжээ. *Ортаг* хэмээн нэрлэгдсэн монголчуудын түнш худалдаачид Чингис хааны үеэс эхлэн язгууртнуудын хөрөнгийг өсгөж өгөхөд туслах болсон юм. Бас хааны сангаас эдгээр ортагт мөнгө олгож байсан байна. *Ортаг*-ууд татварын түрээс эрхлэгчидтэй хамтран ажиллаж байсан байх өндөр магадлалтай. Татварын орлогыг түргэн хураахын тулд Хойд Хятадын иргэдэд их хэмжээгээр зээл олгосон нь зээлийн эрсдэлийн хэмжээг нэмэгдүүлсэн юм. Монголын язгууртнууд өөрсдийн мөнгөн орлогыг *ортаг*-уудад олгож байсан нь тэдний гарт мөнгөний зээлийн эх үүсвэр их хэмжээтэй төвлөрүүлсэн. Эргэн төлөгдөх боломжгүй болсон зээлд хөрөнгө оруулагчдын хөрөнгийг түгжсэн *ортаг*-ууд монголчуудад оруулсан хөрөнгийг нь эргүүлэн төлөх боломжгүй болсон. Үүний уршгаар Монголын язгууртнууд (ялангуяа хааны гэр бүл, хамаатнууд) асар их хэмжээний хохирол амсах эрсдэлд орсон байна. Иймээс энэ явдлыг Өгэдэй хаан өөрийн биеэр зохицуулахаар болжээ.

Дэлхийн түүхэнд болж байсан олон жишээг харахад зарим шаардлагатай үед татварын түрээс эрхлэгчид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед тэднийг дампуурлаас аварч, орлогын түрээсийг цуцлахгүйн тулд улсаас их хэмжээний нөхөн төлбөр олгох, төлбөрөөс хэлтрүүлэх хэрэгтэй болдог байсан⁴⁸.

⁴⁷ 元史，第二章，37.

⁴⁸ Matthew, George T. *The Royal General Farms in Eighteenth-Century France*. New York, Columbia University Press, 1958, 266-269.

Өгэдэй болон түүний засгийн газар өөрсдийг нь санхүүгийн нөөцөөр тасралтгүй хангаж байсан *ортаг*-уудыг золиослохыг хүсээгүй нь мэдээж. Хааны сангаас их хэмжээний мөнгийг зарлагдаж, татвар төлөгчдийн өрийг барагдуулсныг *ортаг* болон тэдний хөрөнгө оруулагч монголчууд ихэд талархан хүлээн авчээ. Ийм шийдвэрт хамгийн их хүчтэй нөлөөлсөн улс төрийн хүчин бол хөрөнгө оруулалтаа аюулгүй эргүүлэн татах гэж хааны гэр бүл, хамаатнууд шаардаж байсан явдал юм. Олон жил өнгөрсөн хойно ч Өгэдэй хааны өгөөмөр зан чанарын талаар хүмүүс мартаагүй байна.

Хойд Хятадын төсвийн асуудлыг сайжруулахаар Өгэдэй 1241 онд Махмуд Ялавачыг захирагчаар томилсон байна. Түүний захиргааны хатуу чанд байдал татварын түрээс эрхлэгчид, *ортаг*-уудад халтай байсан гэж Томас Аллсен үзжээ⁴⁹. Хэрэв татварын түрээс эрхлэгчдэд хатуу хяналт тавьж байсан бол энэ нь тийм удаан үргэлжилсэнгүй. Хаан өөд болсны дараа төрийн хэргийг түр хамаарч байсан их хатан Дөрэгэнэ хааны захирагч Махмуд Ялавачыг зайлуулж, Хятадын захиргаа, санхүүгийн ажлыг Абд ал-Рахманд дахин даалгасан байна. Елюй Чуцай бас дахин эсэргүүцсэн ч түүнийг их хатан сонсоогүй байна. 1246 онд Гүюгийг хаан сууринд суух хүртэл бараг таван жил тэр уг албан тушаалыг хашжээ. Абд ал-Рахманыг цаашдаа хэрхсэн талаар Рашид ал-Дин дараах байдлаар товч өгүүлжээ:

*“Дөрэгэнэ хатны Хятадад захирагчаар илгээсэн ‘Абдал-Рахманыг тэр тонилгож, Хятадын газар нутгийг Сахиб Ялавачид өгсөн.”*⁵⁰

Абд ал-Рахманы талаар өөр дэлгэрэнгүй мэдээлэл Судрын чуулганд байдаггүй. Елюй Чуцай шиг Зүүн Азиас гаралтай олон төрийн түшээд татварын түрээсийг хурцаар шүүмжилж байсан. Дөрэгэнэ хатан төр барьж байх үед Абд ал-Рахман зөвхөн хятад түшмэдүүд гэлтгүй шүтлэг нэгтэй олон дайсантай болсон байв. Ийм учраас тэдний уур хилэнг тайтгаруулж, хаанчлалаа бэхжүүлэхийн тулд шинэ хаан Абд ал-Рахманыг цаазалсан байна. Эцгийнхээ үеийн сайд, түшмэдүүдийг Гүюг эгүүлэн төрийн албанд авч, ээжийнхээ томилсон гол захирагчдаас ганцхан Аргун Агаг үлдээжээ. Хойд Хятадад эдийн засгийн хямрал авчирсан татварын түрээс эрхлэгч, худалдаачин Абд ал-Рахманы хувь заяа ийнхүү эмгэнэлтэйгээр төгссөн байна. Гэвч худалдаачдын нөлөө алтан ургийн гишүүдийн дунд огт буураагүй юм.

Эцэст нь дүгнэхэд монголчуудын засаг захиргааны хүчин чадавх, өргөн хэрэглэж байсан түрээсийн бүтэц нь татварын түрээсийн хэрэгжилтэд нөлөөлсөн

⁴⁹ Allsen, Thomas T. “Mongolian Princes and Their Merchant Partners, 1200-1260”. *Asia Major* 2, no. 2. 1989, 103.

⁵⁰ Rashid al-Din, Fazlullah Hamadani. *The Successors of Genghis Khan*, translated by John A. Boyle. New York, Columbia University Press, 1971, 183.

байна. Монголчууд тогтмол дүнгийн гэрээг түгээмэл ашигладаг байв. Тогтмол дүнгийн гэрээ нь монголчуудын засаг захиргаанд богино хугацааны дотор их хэмжээний орлого оруулах боломжийг олгож байсан байна. Орлогын түрээсийн гэрээг ихэвчлэн богино хугацаагаар монголчууд олгодог байжээ. Ил-хаадын улсад гарч байсан улс төрийн тогтворгүй байдал нь татвар хураах ажлыг түрээсээр эрхлэгчдийг богино хугацааны үр ашгийг илүү анхаарахад хүргэж байсан байна. Монголчуудад хүн хүчний нөөц хангалтгүй байснаас болж бодит байдал дээр татварын түрээсийн үйл ажиллагаанд хатуу хяналт тэр бүр тавьж чаддаггүй байв. Үүний улмаас татварын түрээс монголчуудын засаг захиргаанд ихээхэн эрсдэл авчирч байжээ. Тухайлбал, эзлэгдсэн орны иргэд татвар хураагчдын харгислал, хүчирхийлэлд өртөж, татварын хүнд дарамтад орж байсан юм.

Abstract: This article discusses the application of tax farming in the Mongol Empire. A wide variety of taxes were leased by the Mongol rulers to contractors who mostly promised to collect large revenues from particular provinces. Fragmentary primary sources indicate that tax farming was introduced to the fiscal system of the Mongol Empire in the late 1230s and the tax farming system continued in the Ilkhanate. Due to the Mongol administrators' low monitoring capacity, the abusive power of tax farmers led to the fiscal turbulence. While short-term tax farming contracts brought large amounts of money to the khan's treasury within a short period of time, the tax farming system increased the tension between the conquerors and the conquered.

Ном зүй

1. Azabou, Mongi and Jeffrey B. Nugent, "Contractual Choice in Tax Collection Activities: Some Implications of the Experience with Tax Farming." *Journal of Institutional and Theoretical Economics (JITE)/ Zeitschrift für die gesamte Staatswissenschaft*. 144, no. 4 (1988), 684-705.
2. Allsen, Thomas, "Mongolian Princes and Their Merchant Partners, 1200-1260." *Asia Major* 2, no. 2 (1989), 83-126
3. Buell, Paul. "Cinqai." in *In the Service of the Khan: Eminent Personalities of the Early Mongol-Yuan Period (1200-1300)*, ed. de Rachewiltz, Igor et al. Wiesbaden, Otto Harrassowitz, 1993.
4. Cizakca, Murat. "Tax-Farming and Resource Allocation in Past Islamic Societies." *Islamic Economics* 1 (1989), 59-80
5. Collins, James. *Fiscal Limits of Absolutism: Direct Taxation in Early Seventeenth Century France*. Los Angeles and London, University of California Press, 1988.
6. Gibbs, Matt. "Tax farming." *The Encyclopedia of Ancient History*, ed. Bagnall, Roger; Brodersen, Kai; Champion, Craige; and Erskine, Andrew. London, Wiley-Blackwell, 2012.

7. Греков, Борис Дмитриевич и Аркадий Лаврович Сидоров. *Очерки истории СССР 14-15 вв.* Москва, Академия Наук СССР, 1953.
8. Halperin, Charles. *Russia and the Golden Horde: The Mongol Impact on Medieval Russian History.* Bloomington, Indiana University Press, 1987.
9. Halperin, Charles. *The Tatar Yoke: The Image of the Mongols in Medieval Russia (Corrected Edition).* Bloomington, Slavic Publishers, 2009.
10. Jang, Sungkyu. *Three Essays on Tax Collection: A Historical Review, A Formal Model, and an Empirical Test of the Government's Contractual Choice of Tax Collection Between Tax Farming and Tax Bureaucracy.* Tallahassee, The Florida State University, 2012.
11. Jackson, Gregory and Anastasia Petraki. *Understanding the Short-termism: Corporate Governance.* Stockholm, Glasshouse Forum, 2011.
12. http://www.glasshouseforum.org/pdf/GF_jackson-petraki_short-termism.pdf
13. Kiser, Edgar, "Markets and Hierarchies in Early Modern Tax Systems: A Principal-Agent. Analysis." *Politics and Society* 22, no. 3 (1994), 284-315.
14. Lambton, Ann. *Continuity and Change in Medieval Persia.* New York: Suny Press, 1988.
15. -----."Mongol Fiscal Administration in Persia (Part II)." *Studia Islamica*, no. 65 (1987), 97-123.
16. -----."Wakf in Persia". *The Encyclopaedia of Islam, vol. XI: W-Z, ed. Bearman, Peri; Bianquis, Thierry; Bosworth, Edmund; Van Donzel, Heinrichs, Wolfhart.* Leiden, Brill, 2002.
17. Lane, George. *Early Mongol Rule in Thirteenth-Century Iran: A Persian Renaissance.* London and New York, Routledge Curzon, 2003.
18. Ma, Jun, "New Public Management in the Early Modern Period: Lessons from Tax Farming History." *Administrative Theory & Praxis* 25, no. 4 (2003), 435-456.
19. Maddison, Angus. *Contours of the World Economy, 1-2030 AD: Essays in Macro-Economic History.* Oxford, Oxford University Press, 2007.
20. Martinez, Arsenio Peter. "Institutional Development, Revenues and Trade". *The Cambridge History of Inner Asia: The Chinggisid Age.* Cambridge, Cambridge University Press, 2009: 89-108
21. Matthew, George. *The Royal General Farms in Eighteenth-Century France.* New York, Columbia University Press, 1958.
22. Muhs, Brian. *The Administration of Egyptian Thebes in The Early Ptolemaic Period, Ph.D. Dissertation.* University of Philadelphia, 1996.
23. Müller, Christian and Johannes Pahlitzsch, "Sultan Baybars I and the Georgians: In the Light of New Documents Related to the Monastery of the Holy Cross in Jerusalem." *Arabica* 51, no. 3 (2004), 258-290.
24. Narayanan, M. P., "Form of Compensation and Managerial Decision Horizon." *The Journal of Financial and Quantitative Analysis*, no. 31 (1996), 467-491.
25. Насонов, Арсений Николаевич, *Монголы и Русь: История Татарской политики на Руси.* Москва и Ленинград, Академия Наук СССР, 1940.
26. Rashid al-Din, Fazlullah Hamadani. *Rashiduddin Fazlullah's Jami' u' t-tawarikh, A Compendium of Chronicles: A History of the Mongols.* 3 vols. translated by Wheeler M. Thackston. Cambridge, Harvard University Press, 1998-99.
27. Rashid al-Din, Fazlullah Hamadani. *The Successors of Genghis Khan,* translated by John A. Boyle. New York, Columbia University Press, 1971.

28. De Rachewiltz, Igor. "Yeh-lü Ch'u-ts'ai, Yeh-lü Chu, Yeh-lü Hsi-liang." in *In the Service of the Khan: Eminent Personalities of the Early Mongol-Yuan Period (1200-1300)*, ed. de Rachewiltz, Igor et al. Wiesbaden: Otto Harrassowitz, 1993.
29. Rossabi, Morris. *Khubilai Khan: His Life and Times*. Berkeley, University of California Press, 1988.
30. Schurmann, Herbert. *Economic Structure of the Yuan Dynasty: Translation of Chapters 93 and 94 of the Yuan shih*. Cambridge: Harvard University Press, 1956.
31. Schurmann, Herbert. "Tributary Practices of the Thirteenth Century." *Harvard Journal of Asiatic Studies* 19, no. 3/4 (1956), 304-389.
32. Stella, Peter. "Tax Farming: A Radical Solution for Developing Country Tax Problems?." *IMF Staff Papers*. 40, no. 1 (1993).
33. 元史. 北京市: 中华书局出版社, 1976.